2027 ОНЫ ХАВРЫН СЕМЕСТР

# Элсэлтийн Гарын Авлага

# Олон Улсын Оюутнуудад

# SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY

Сүншин Эмэгтэй Их Сургууль SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY

INTERNATIONAL EDUCATION QUALITY ASSURANCE SYSTEM

# 12 consecutive years as a Best Accredited University

CERTIFIED BY THE MINISTRY OF EDUCATION, REPUBLIC OF KOREA




Sungshin Women's University has been named a Best Accredited University for 12 consecutive years under the International Education Quality Assurance System (IEQAS) of the Ministry of Education, an official national recognition of the university's capacity to recruit and support international students.

Accreditation period | March 2026 ~ February 2027

A star that brightens society, leading the future

**Sungshin Women's University**

SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY

SUNGSHIN
WOMEN'S UNIVERSITY

# Admission Procedure

## ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

**1**

### Цахим бүртгэл

jinhakapply.com

1-р шат: 2026. 10. 21. ~ 12. 02.
2-р шат: 2027. 1. 4. ~ 1. 11.

**2**

### Бүртгэлийн хураамж төлөх

Цахим бүртгэлийн үед төлнө

**3**

### Материалын эх хувийг илгээх

Шуудангаар эсвэл биечлэн
Цахим бүртгэлийн
хугацаатай ижил

**4**

### Материалын үнэлгээ

1-р шат: 2026. 12. 03-наас
2-р шат: 2027. 1. 12-ноос

**5**

### Тэнцсэн эсэхийг зарлах

1-р шат: 2026. 12. 30.
2-р шат: 2027. 1. 27.

**6**

### Сургалтын төлбөр төлөх

1-р шат: 2026. 12. 30. ~ 2027. 1. 6.
2-р шат: 2027. 1. 27. ~ 1. 29.

**7**

### Санхүүгийн баталгааны материал илгээх

Төлбөр төлсний дараа шууд

**8**

### Дотуур байранд бүртгүүлэх

Дотуур байрны цахим
хуудсанд зарлана
(https://www.sungshin.ac.kr/
(sites/dormitory/index.do)

1-р шат: 2027. 1. 13. (төлөвлөсөн)
2-р шат: 2027. 2. 3. (төлөвлөсөн)

**9**

### Стандарт элсэлтийн зөвшөөрөл олгох

1-р шат: 2027. 1. 13-наас
2-р шат: 2027. 2. 3-наас
дараалан олгоно

**10**

### Виз мэдүүлэх ба Солонгост ирэх

Элсэлтийн зөвшөөрөл авсны
дараа хувиараа мэдүүлнэ

**11**

### Танилцуулах сургалт

Цахимаар: 2027. 2. 12.
Танхимаар: 2027. 2. 25.

**12**

### Хичээл эхлэх

2027. 3. 2.

※ Дээрх хуваарь сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.


**SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY**
International Affairs and Services Team

# UNIVERSITY QUICK FACTS

## 01 GLOBAL PARTNERSHIPS

**58**
Countries

**357**
Universities

## 02 ENROLLMENT

**11,850**
Undergraduate Students

**630**
Graduate Students

**2,121**
International Students

**531**
Sungshin Outgoing Students

## 03 ACADEMIC PROGRAMS

**12**
Colleges

**50**
Departments & Schools

Graduate School
**46-34-30**
Master's · Doctoral · Integrated

## 04 OUTBOUND SHORT-TERM PROGRAM

**01** Korea-ASEAN Youth Exchange Program
Exchange with Vietnam & Thailand

**02** Korea-China-Japan Asian Women Leadership Program
Leadership camp for Korea, China & Japan

**03** K-Central Asia: STEM Youth Silk Road Program
AI & CS projects with Kazakhstan & Uzbekistan

## 05 DORMITORY FOR INTERNATIONAL STUDENTS

6 buildings exclusively for international students
(The House / Sungmiryo, university-operated · 1-4 person rooms)



| Dormitory | Room Type | Fee per Semester (KRW) | Approx. USD |
|---|---|---|---|
| External Dormitories (6 buildings) | 1, 2, 3, 4-person | KRW 1,537,500 ~ 2,940,000 | USD 1,143 ~ 2,186 |
| The House | 2-person | KRW 2,097,380 | USD 1,559 |
| Sungmiryo (University-operated) | 1, 2, 3, 4-person | KRW 1,115,630 ~ 2,677,500 | USD 829 ~ 1,991 |

※ Please refer to the admission guide for detailed rates. Fees are subject to change.

Converted at 1 USD = 1,345 KRW (approx.)

SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY
International Affairs and Services Team




# Soojung Campus

DONAM, SEOUL

The flagship campus of Sungshin Women's University,
where history, tradition and innovation coexist

## Colleges and Departments

| College | Department |
|---|---|
| College of Humanities and Convergence Arts | Korean Language & Literature, English Language & Literature, German Language, Literature and Culture, French Language, Literature and Culture, Japanese Language, Literature and Culture, Chinese Language, Literature and Culture, History |
| College of Social Sciences | Political Science and Diplomacy, Psychology, Geography, Economics, Media Communication, School of Business Administration |
| College of Law | School of Law |
| College of Natural Sciences | School of Mathematics, Statistics and Data Science |
| College of IT Convergence | AI Convergence, Convergence AI Semiconductor Engineering, Computer Engineering, Convergence Security Engineering, Service Design Engineering |
| College of Education | Education, Social Studies Education, Ethics Education, Chinese Classics Education, Early Childhood Education |
| College of Fine Arts | Oriental Painting, Western Painting, Sculpture, Crafts, Design |
| College of Music | Vocal Music, Instrumental Music, Composition |
| College of Living Industry | School of Sports Science (Sports Leisure, Exercise Rehabilitation) |

A star that brightens society, leading the future

**Sungshin Women's University**

SUNGSHIN
WOMEN'S UNIVERSITY




# Woonjung Green Campus

MIA, SEOUL

A future-oriented global campus
where creative talent grows

## Colleges and Departments

| College | Department |
|---|---|
| College of Creativity and Convergence | International School of Korean Culture and Technology (Global Korean Studies, Beauty and Fashion Design) |
| College of Humanities and Convergence Arts | Culture & Art Management, Acting for Visual Media, Contemporary Music, Dance Art |
| College of Social Sciences | Social Welfare |
| College of Natural Sciences | School of Chemistry and Energy (Chemistry, Smart Energy), School of Biohealth Convergence (Biohealth Service, Food and Nutrition) |
| College of Engineering | Materials Science and Engineering, Food Science and Biotechnology, School of Biopharmaceutical and Medical Sciences |
| College of Nursing Sciences | Nursing Science |
| College of Living Industry | Fashion Industry, Consumer Science and Living Culture Industry, Beauty Industry |

A star that brightens society, leading the future

**Sungshin Women's University**

SUNGSHIN
WOMEN'S UNIVERSITY

# ГАРЧИГ

**I. Элсэлтийн хуваарь** ·····8

**II. Элсэлт авах мэргэжлийн тэнхим** ·····9

**III. Тавигдах шаардлага** ·····11

**IV. Өргөдөл гаргах арга** ·····12

**V. Бүрдүүлэх баримт** ·····15

**VI. Сонгон шалгаруулалтын хэлбэр ба арга** ·····18

**VII. Анхаарах зүйлс** ·····19

**VIII. Сургалтын тэтгэлэг**·····20

**IX. Сургалтын төлбөр**·····23

**X. Англи хэлтэй орны жагсаалт**·····23

**XI. Дотуур байр**·····24

# I. ЭЛСЭЛТИЙН ХУВААРЬ

| Ангилал | Хугацаа | | Тайлбар |
|---|---|---|---|
| | 1-р элсэлт | 2-р элсэлт | |
| **Өргөдөл хүлээн авах** | **2026.10.21. (Лхагва) 10:00 ~ 2026.12.02. (Лхагва) 17:00** | **2027.01.04. (Даваа) 10:00 ~ 2027.01.11. 17:00 (Даваа)** | **Онлайн бүртгэл хийх**<br>- Сургуулийн элсэлтийн бүртгэлийн цахим хуудас (https://ipsi.sungshin.ac.kr)<br>- Жинхаг apply бүртгэлийн цахим хуудас (http://www.jinhakapply.com/) |
| **Бүрдүүлсэн баримт хүлээн авах** | **2026.10.21. (Лхагва) 10:00 ~ 2026.12.02. (Лхагва) 17:00** | **2027.01.04. (Даваа) 10:00 ~ 2027.01.11. 17:00 (Даваа)** | **Шуудангаар болон өөрийн биеэр ирж өгөх бол**<br>- Шуудангаар илгээсэн баримт зөвхөн бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө хүлээж авсан материалийг тооцно.<br>- Өөрийн биеэр ирж өгөх : Ажлын өдөр 10:00 ~ 17:00 (Үдийн цайны цагаар хүлээн авахгүй 12:00 ~ 13:00 )<br>※ **Бичиг баримтаа заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.**<br>※ **Анхаарах зүйл: Баримт бичиг илгээхдээ заавал Jinhak Apply (진학어플라이) вэбсайтаас шуудангаар илгээх зориулалтын хавтас/шошгыг хэвлэж авч наан илгээх шаардлагатай.**<br>※ **Илгээх хаяг: (03162) #1007, 10F, Hanaro Building, 25 Insadong 5-gil, Jongno-gu Seoul, Republic of Korea International Admissions Service Center** |
| **Тэнцэгчдийн нэрсийн жагсаалтыг зарлах** | **2026.12.30. (Лхагва) 10:00** | **2027.01.27. (Лхагва) 10:00** | Сургуулийн элсэлтийн бүртгэлийн цахим хуудас (https://ipsi.sungshin.ac.kr) |
| **Тэнцэгчийн гэрчилгээ, сургалтын төлбөрийн нэхэмжлэлийн хуудас хэвлэж авах** | **2026.12.30 (Лхагва) ~ 2027.01.06 (Лхагва)** | **2027.01.27. (Лхагва) ~ 01.29. (Баасан)** | |
| **Төлбөр төлөх хугацаа** | **2026.12.30 (Лхагва) ~ 2027.01.06 (Лхагва)** | **2027.01.27. (Лхагва) ~ 01.29. (Баасан)** | Төлбөр төлөх заавар: **Flywire эсвэл Солонгос дотроо дансаар шилжүүлэх (Олон улсын гүйлгээ хийх боломжгүй)** |
| **Хичээл эхлэх** | **2027.03.02 (Мягмар)** | | |

※ Тус сургуулийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг харгалзан дээрхи цагийн хуваарьт өөрчлөлт оруулж болно.

※ 2 дахь нэмэлт элсэлт нь Солонгост одоо амьдарч байгаа болон виз хурдан авах боломжтой оюутнуудад зориулагдсан болно. 2 дахь нэмэлт элсэлтэнд тэнцсэн оюутнуудад сургалтын төлбөрөө төлж, шаардлагатай бичиг баримтаа өгсөн оюутнуудад 2027 оны 2-р сарын 03-ны Лхагва гарагаас урилгыг олгоно. Виз солиход цаг хугацааны хувьд ямар нэгэн асуудалгүй тохиолдолд л бүртгүүлнэ үү.

※ Бүх хуваарыг Солонгосын цагаар тооцоно.

# II. ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМ

## 1. ШИНЭ ЭЛСЭГЧ

▣ Элсэгчийн тоонд хязгаар тавихгүй боловч тэнхим(анги)-ийн элсүүлэх оюутны тоо, өргөдөл гаргагчийн суралцах чадварыг харгалзан шалгаруулж авна.

***Урлаг, биеийн тамирын сургалттай тэнхим**

****Англи хэлний ангийн элсэлт**

| БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУД | ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМ | |
|---|---|---|
| Урлаг соёл, бүтээлийн их сургууль | Олон улсын тэнхим | Global солонгос судлал (К-соёл ба энтертайнмент чиглэл) |
| | | Гоо сайхан, загварын дизайны мэргэжил |
| Хүмүүнлэгийн ухаан, урлагийн сургууль | Солонгос хэл уран зохиолын тэнхим, англи хэл уран зохиолын тэнхим, герман хэл уран зохиол·соёлын тэнхим, франц хэл уран зохиол·соёлын тэнхим, япон хэл уран зохиол·соёлын тэнхим, хятад хэл уран зохиол·соёлын тэнхим, түүхийн тэнхим, соёл урлагийн менежментийн тэнхим, **Медиа бичлэг боловсруулах, жүжиглэх урлагийн тэнхим*, орчин үеийн хэрэглээний хөгжим судлалын тэнхим*, бүжгийн урлагийн тэнхим*** | |
| Нийгмийн шинжлэх ухааны сургууль | Улс төр олон улсын харилцааны тэнхим, сэтгэл судлалын тэнхим, газар зүйн тэнхим, санхүү эдийн засгийн тэнхим, медиа мэдээлэл харилцааны тэнхим, бизнесийн удирдлагын тэнхим, нийгмийн халамжийн тэнхим | |
| Хуулийн сургууль | Хууль эрх зүйн тэнхим | |
| Байгалийн шинжлэх ухааны сургууль | Математик статистикийн мэдээллийн шинжлэх ухааны тэнхим(математикч/финтекч), математик статистикийн мэдээллийн шинжлэх ухааны тэнхим(Статистик/мэдээллийн сангийн шинжлэх ухааны мэргэжилтэн), хими·эрчим хүчний тэнхим(хими/смарт эрчим хүчний мэргэжилтэн), Биологийн эрүүл мэндийн нэгдлийн тэнхим (Био эрүүл мэндийн үйлчилгээ/Хүнс, хоол тэжээлийн мэргэжил) | |
| Инженерийн сургууль | Цэвэр материалын инженерчлэлийн тэнхим, Био-хүнсний инженерийн тэнхим, Био эмийн шинжлэх ухааны тэнхим (Биотехнологи/Биофармацевтикийн шинжлэх ухаан/Дэлхийн анагаах ухааны шинжлэх ухаан) | |
| Мэдээллийн технологийн сургууль | Хиймэл оюун ухааны интеграцчилал судлалын тэнхим, Нэгдсэн хиймэл оюун ухаант хагас дамжуулагч инженерчлэлийн тэнхим, Компьютерийн инженерчлэлийн салбар, Нэгдсэн аюулгүй байдлын инженерчлэлийн салбар, Үйлчилгээний дизайн инженерчлэлийн салбар | |
| Сувилахуйн ухааны сургууль | Сувилахуйн ухааны тэнхим | |
| Ахуйн гоо сайхан үйлдвэрлэлийн олон улсын сургууль | Хувцас үйлдвэрлэлийн тэнхим, Хэрэглэгчийн аж үйлдвэрийн тэнхим, Гоо сайхны үйлдвэрлэлийн тэнхим*, Спортын шинжлэх ухааны салбар (Спорт, амралт чөлөөт цагийн мэргэшил)*, Спортын шинжлэх ухааны салбар (Дасгал хөдөлгөөнөөр нөхөн сэргээх мэргэшил) | |
| Багшийн сургууль | Боловсрол судлалын тэнхим, нийгмийн ухааны боловсролын тэнхим, ёс зүйн боловсролын тэнхим, ханз бичгийн боловсролын тэнхим, сургуулийн өмнөх боловсролын тэнхим | |
| Дүрслэх урлагийн сургууль | Дорно дахины уран зураг судлалын тэнхим*, өрнө дахины уран зураг судлалын тэнхим*, уран баримал судлалын тэнхим*, гар урлалын тэнхим*, дизайн судлалын тэнхим* | |
| Хөгжмийн сургууль | Дуулах урлагийн тэнхим*, хөгжмийн урлагийн тэнхим*, хөгжим, ая зохиох урлагийн тэнхим* | |

※ Бүх мэргэжлээр эмэгтэй оюутан элсүүлнэ. **(Зөвхөн Олон улсын тэнхим хүйс харгалзахгүй элсэх боломжтой)**

※ Багшийн сургуульд элсүүлэх оюутны тоог боловсролын яамны ‘Багшлах боловсон хүчин бэлтгэн гаргах боловсролын байгууллагуудын оюутан элсүүлэх(бусад) журам’-ын дагуу бүх тэнхимд элсүүлэх нийт оюутны 10%-тай дүйцэх тооны оюутан шалгаруулж авна.

## 2. ШИЛЖИН СУРАЛЦАГЧ

▣ Элсэгчдийн тоонд хязгаар тавихгүй боловч тэнхмийн оюутан элсүүлэх тоо, өргөдөл гаргагчийн суралцах чадварыг харгалзан шалгаруулж авна.

***Урлаг, биеийн тамирын тэнхим(анги)**
****Англи хэлний ангийн элсэлт**

| БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУД | ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМ | |
|---|---|---|
| Бүтээлч, нэгдмэл судлалын коллеж | Олон улсын тэнхим | - Глобал Солонгос судлалын мэргэжил (Солонгос хэл, заах арга )<br>- Глобал Солонгос судлалын мэргэжил (K-Culture & Entertainment чиглэл)<br>- Гоо сайхан · Загвар дизайны мэргэжил |
| Хүмүүнлэгийн ухаан, урлагийн сургууль | Солонгос хэл, уран зохиолын тэнхим, Англи хэл, уран зохиолын тэнхим, Герман хэл, утга зохиол, соёлын тэнхим, Франц хэл, утга зохиол, соёлын тэнхим, Япон хэл, утга зохиол, соёлын тэнхим, Хятад хэл, утга зохиол, соёлын тэнхим, Түүхийн тэнхим, Соёл, урлагийн менежментийн тэнхим, Медиа, дүрс бичлэг, жүжиглэлийн тэнхим*, Орчин үеийн нийтийн хөгжмийн тэнхим*, Бүжгийн урлагийн тэнхим* | |
| Нийгмийн шинжлэх ухааны сургууль | Улс төр олон улсын харилцааны тэнхим, сэтгэл судлалын тэнхим, газар зүйн тэнхим, санхүү эдийн засгийн тэнхим, медиа мэдээлэл харилцааны тэнхим, бизнесийн удирдлагын тэнхим, нийгмийн халамжийн тэнхим | |
| Хуулийн сургууль | Хууль эрх зүйн тэнхим | |
| Байгалийн шинжлэх ухааны сургууль | Математик статистикийн мэдээллийн шинжлэх ухааны тэнхим(математикч), математик статистикийн мэдээллийн шинжлэх ухааны тэнхим(пинтекч), математик статистикийн мэдээллийн шинжлэх ухааны тэнхим(Статистикч), математик статистикийн мэдээллийн шинжлэх ухааны тэнхим(мэдээллийн сангийн шинжлэх ухааны мэргэжилтэн), хими·эрчим хүчний тэнхим(хими/смарт эрчим хүчний мэргэжилтэн), Био шинэ эм, анагаах ухааны тэнхим(Био шинэ эм/глобал анагаах ухааны мэргэжилтэн), био эрүүл мэндийн тэнхим(био эрүүл мэндийн үйлчилгээ/хүнс, тэжээлийн мэргэжилтэн) | |
| Шинжлэх ухаан технологийн сургууль | Үйлчилгээний дизайны инженерчлэл, Нэгдсэн ажуулгүй байдлын инженерчлэл, Компьютерын инженерчлэл, Цэвэр технологийн шинэ материалын инженерчлэл, Биотехнологийн хүнсний инженерчлэл, Биотехнологи, амьд биетийн инженерчлэл, Биотехнологийн шинэ эмийн анагаах ухааны шинжлэх ухаан (Биотехнологийн шинэ эмийн мэргэшил), Биотехнологийн шинэ эмийн анагаах ухааны шинжлэх ухаан (Олон улсын анагаах ухааны шинжлэх ухааны мэргэшил), Хиймэл оюун ухааны нэгдсэн сургалт (Хиймэл оюун ухааны мэргэшил), Хиймэл оюун ухааны нэгдсэн сургалт (Ухаалаг эд зүйлсийн интернетийн мэргэшил) | |
| Сувилахуйн ухааны сургууль | Сувилахуйн ухааны тэнхим | |
| Ахуйн гоо сайхан үйлдвэрлэлийн олон улсын сургууль | Хувцас үйлдвэрлэлийн тэнхим, Хэрэглэгчийн үйлвэрлэл аж ахуйн тэнхим, **гоо сайхан үйлдвэрлэлийн тэнхим*, Спортын шинжлэх ухааны салбар (Спорт, амралт чөлөөт цагийн мэргэшил)*, Спортын шинжлэх ухааны салбар (Дасгал хөдөлгөөнөөр нөхөн сэргээх мэргэшил)** | |
| Дүрслэх урлагийн сургууль | **Дорно дахины уран зураг судлалын тэнхим*, өрнө дахины уран зураг судлалын тэнхим*, уран баримал судлалын тэнхим*, гар урлалын тэнхим*, аж үйлдвэрийн дизайн судлалын тэнхим*** | |
| Хөгжмийн сургууль | **Дуулах урлагийн тэнхим*, хөгжмийн урлагийн тэнхим*, хөгжим, ая зохиох урлагийн тэнхим*** | |

※ Бүх мэргэжлээр эмэгтэй оюутан элсүүлнэ. **(Зөвхөн Олон улсын тэнхим хүйс харгалзахгүй элсэх боломжтой)**

※ Жич, гадаад харилцаа тогтоосон их сургуулийг ‘Нүүр будалтын дизайн’ мэргэжлээр дипломын (тусгай мэргэжлийн) зэрэгтэй төгсөгчид сурах явцдаа манай сургуулид 1-ээс дээш хичээлийн улиралд солилцооны оюутнаар ирж байсан бол өргөдөл гаргагчийн хүйснээс үл хамааран ‘Гоо сайхан үйлдвэрлэлийн тэнхим’-д хичээлийн дундаас орж сурах өргөдөл гаргаж болно

## 3. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

▣ Дараахи элсэлт авах тэнхмийн сургалтууд нь боловсролын яамны албан ёсны байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн болно.

| ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМ | Магадлан итгэмжлэл хийдэг байгууллага | Магадлан итгэмжлэгдсэн эсэх | Хүчинтэй хугацаа | Тайлбар |
|---|---|---|---|---|
| **Сувилахуйн ухааны тэнхим** | Солонгосын Сувилахуйн Ухааны Боловсролын Үнэлгээний Төв | **Итгэмжлэгдсэн** | ~ 2027.12.16. | Бакалаврын сургалт |

# Ⅲ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

## 1. ШИНЭ ЭЛСЭГЧ

▣ Дараахи шаардлагыг хангасан байна

| | Тавигдах шаардлага | |
|---|---|---|
| | **Олон улсын оюутны тэнхим** | **Олон улсын оюутны тэнхимээс бусад тэнхим** |
| Шинэ элсэгч (1-р курс) | ① (Ахлах сургуулийн сургалтын хөтөлбөртэй дүйцэх сургалтанд хамрагдаж эхлэхийн өмнө)Эцэг·эх болон өөрөө гадаад улсын харъяалалтай иргэн байх<br>② Дотоод·гадаадын ахлах сургууль төгссөн, эсвэл 2027 оны 2 сард төгсөх гэж байгаа хүн (GED зэрэг дотоод·гадаадын ахлах сургуулийн шалгалтыг эчнээгээр сурч өгсөн, гэрийн сургалт, кибер сургалтаар эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөхгүй) | |
| | **③[Англи хэл дээрх анги]**<br>- TOEFL IBT*3,5оноо, IELTS 5.5 онооноос дээш эсвэл Англи хэлийг эх хэл эсвэл хууль ёсны албан ёсны хэл болгон ашигладаг улсын иргэн<br>*TOEFL IBT : 2026оны 1сарын 20ны дотор өгсөн шалгалт бол 59 онооноос дээш байх<br>**Англи хэл албан ёсны хэлээр хэрэглэдэг улс орны жагсаалтыг 23-р хуудаснаас үзнэ үү | **③ Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK) 3-аас дээш зэрэгтэй байх**<br>※ СОНШИН сургуулийн Солонгос хэлний бэлтгэлийн 4-р түвшнээс дээш төгсөгчид нь TOPIK оноогүйгээр элсэх боломжтой.<br>※ Урлаг, биеийн тамирын чиглэлийн анги болон Хувцасны үйлдвэрлэлийн мэргэжилд Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK)-ын 2-р түвшнээс дээш оноо авсан хүмүүс ч мөн элсэх боломжтой. Гэхдээ элсэсний дараа манай сургуулийн солонгос хэлний сургалтад 1 жилийн хугацаанд 300-аас дээш цаг солонгос хэлний сургалтад хамрагдах шаардлагатай. |

## 2. ШИЛЖИН СУРАЛЦАГЧ

▣ Дараахи шаардлагыг хангасан байна

| | Эзэмшсэн боловсролд тавигдах шаардлага | |
|---|---|---|
| | Олон улсын судлалын тэнхим | Олон улсын судлалын тэнхимээс бусад мэргэжил, салбар |
| Шилжин суралцагч (3-р курс) | ① (ЕБС-ийн хөтөлбөртэй дүйцэх боловсролын сургалтыг эхлүүлэхээс өмнө) эцэг, эх болон өөрөө бүгд гадаадын иргэн байх<br>② Дотоодын болон гадаадын 4 жилийн хугацаатай их, дээд сургуулийн 2-р курс буюу 4 улирал ба түүнээс дээш хугацааг амжилттай дүүргэсэн (2027 оны 2-р сард дүүргэхээр төлөвлөж буй оюутан мөн хамаарна), Бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт кредитийн 1/2 буюу түүнээс дээшийг судалсан байх, эсхүл дотоодын болон гадаадын мэргэжлийн коллеж (2–3 жилийн хөтөлбөр) төгссөн (2027 оны 2-р сард төгсөхөөр төлөвлөж буй оюутан мөн хамаарна), эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу үүнтэй адил буюу түүнээс дээш түвшний боловсрол эзэмшсэнд хүлээн зөвшөөрөгдсөн элсэгч | |
| | ③ **[Солонгос хэлний чиглэл]**<br>- Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK)-ын 3-р түвшин буюу түүнээс дээш түвшинтэй байх<br>※ Манай СОНШИН сургуулийн Солонгос хэлний бэлтгэлийн 4-р түвшин буюу түүнээс дээш түвшнийг дүүргэсэн бол TOPIK-ийн оноогүй байсан ч элсэх боломжтой.<br>**[Англи хэлний чиглэл]**<br>- IELTS 5.5 буюу түүнээс дээш, эсвэл TOEFL iBT 3.5 буюу түүнээс дээш*, эсвэл англи хэл нь төрөлх хэл буюу хууль ёсны албан ёсны хэл нь болсон улсын иргэн байх.<br>*TOEFL iBT: 2026 оны 1-р сарын 20-ны дотор шалгалт өгсөн бол 59 оноо буюу түүнээс дээш байх.<br>** Англи хэл албан ёсны хэлээр хэрэглэдэг улс орны жагсаалтыг 23-р хуудаснаас харна уу. | **③ Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK) 3-аас дээш зэрэгтэй байх**<br>※ Манай СОНШИН сургуулийн Солонгос хэлний бэлтгэлийн 4-р түвшнээс дээш төгсөгчид нь TOPIK оноогүйгээр элсэх боломжтой.<br>※ Урлаг, биеийн тамирын чиглэлийн анги болон Хувцасны үйлдвэрлэлийн мэргэжилд Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK)-ын 2-р түвшнээс дээш оноо авсан хүмүүс ч мөн элсэх боломжтой. Гэхдээ элсэсний дараа манай сургуулийн солонгос хэлний сургалтад 1 жилийн хугацаанд 300-аас дээш цаг солонгос хэлний сургалтад хамрагдах шаардлагатай. |

- Хичээлийн амралтаар сонссон хичээлийн кредит оноо болон сурлагын дүн хүлээн зөвшөөрөгдөх боловч хичээлийн үндсэн улирлыг төгсөж дүүргэсэнд тооцохгүй.
- Сертификат олгодоггүй сургууль төгссөн бол 2-р курс эсвэл 4-өөс дээш улирлын хичээлд сууж дүүргээд бакларын зэрэг авахад шаардлагатай босго онооны 1/2-ээс дээш(Англиин 3 жилийн сургалттай дээд сургуулийн оюутнууд 2/3-оос дээш кредит цуглуулсан байна) хувийг цуглуулсан байна.
- Урлаг, биеийн тамирын сургалттай тэнхимд зөвхөн энэ чиглэлийн сургуульд сурч байсан оюутнууд элсэх өргөдөл гаргах боломжтой бөгөөд үүнээс бусад чиглэлээр сурч байсан оюутнууд сурч байсан мэргэжлээсээ өөр чиглэлээр элсэх өргөдөл гаргаж болно.
  ※ Спортын шинжлэх ухаан(чөлөөт спортын мэргэжилтэн)-ы, Гоо сайхны аж ахуйн чиглэлээр сурч байсан оюутнууд өөр чиглэлээр элсэх өргөдөл гаргаж болно
- 3-р курст шилжин суралцах (гүүрэн болон шилжин суралцах систем) зарчимтай хэдий ч, дотоод болон гадаадын албан ёсны дээд боловсролын байгууллагад Гоо сайхны үйлдвэрлэлийн чиглэлээр (ижил мэргэжлээр) 3 жилийн хугацаатай мэргэжлийн бакалаврын болон түүнээс дээш зэрэг хамгаалсан гадаад иргэн манай сургуулийн Гоо сайхны үйлдвэрлэлийн ангид шилжин суралцах тохиолдолд суралцах дамжаг 4-р курст дүйцүүлэн тооцож болно.
- Гадаад харилцаа тогтоосон их сургуулийг ‘Нүүр будалтын дизайн’ мэргэжлээр дипломын (тусгай мэргэжлийн) зэрэгтэй төгсөгчид сурах хугацаандаа манай сургуулийн 1-ээс дээш улиралд солилцооны оюутнаар сурч байсан бол хүйснээс үл хамааран ‘Гоо сайхан үйлдвэрлэлийн тэнхим’-д шилжиж орох өргөдөл гаргах боломжтой.

## 2. ШИНЭЭР ЭЛСЭГЧ БОЛОН ШИЛЖИН ЭЛСЭГЧИДЭД ХАМААРАХ ШААРДЛАГА

- TOEFL iBT Home Edition болон MyBest Score-ийг хүлээн зөвшөөрнө.

- Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK), IELTS, TOEFL-ийн онооны хувьд өргөдөл хүлээн авах эцсийн хугацааны байдлаар хүчинтэй хугацаа (2 жил)-д багтаж байгаа баримт бичгийг л хүлээн зөвшөөрнө.

- Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын шаардлагад TOPIK PBT болон iBT (албан ёсны ердийн шалгалт)-ын аль алиныг хүлээн зөвшөөрнө.(TOPIK iBT-ийн туршилтын шалгалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй.)

- TOPIK-ийн 3-р түвшин буюу түүнээс доош түвшний эрхтэй оюутан элсэх боломжтой. Гэхдээ төгсөхөөсөө өмнө TOPIK-ийн 4-р түвшин буюу түүнээс дээш түвшнийг заавал авсан байх шаардлагатай.

※ БНСУ-н давхар иргэншилтэй иргэд энэхүү гадаад оюутан элсүүлэх журмын дагуу өргөдөл гаргах боломжгүй

# IV. ӨРГӨДӨЛ ГАРГАХ АРГА

## 1. ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ

### 1) 1 дүгээр элсэлт

| Ангилал | Өргөдөл хүлээн авах | Баримт бүрдүүлж өгөх |
|---|---|---|
| Хугацаа | 2026.10.21. (Лхагва) 10:00 ~ 2026.12.02. (Лхагва) 17:00 | 2026.10.21. (Лхагва) 10:00 ~ 2026.12.02. (Лхагва) 17:00 |
| Бүртгэл хийх арга | Онлайн бүртгэл хийх | **Шуудангаар болон өөрийн биеэр ирж өгөх бол**<br>- Шуудангаар илгээсэн баримт зөвхөн бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө хүлээж авсан материалийг тооцно.<br>- Өөрийн биеэр ирж өгөх: Даваа~Баасан 10:00 ~ 17:00 (Үдийн цайны цагаар хүлээн авахгүй 12:00 ~ 13:00)<br>※ **Бичиг баримтаа заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.**<br>※ **Олон нийтийн амралтын өдөр материал хүлээж авахгүй** |
| Материал хүлээн авах газар | - Сургуулийн элсэлтийн бүртгэлийн цахим хуудас (https://ipsi.sungshin.ac.kr)<br>- Jinhak apply бүртгэлийн цахим хуудас (http://www.jinhakapply.com/) | Илгээх хаяг:<br>((03162) 서울시 종로구 인사동5길 25 하나로빌딩 10층 1007호<br>(International Admissions Service Center)<br>(03162) #1007, 10F, Hanaro Building, 25 Insadong 5-gil, Jongno-gu Seoul, Republic of Korea<br>(International Admissions Service Center)<br>**Анхаарах зүйл:**<br>**Баримт бичгийг өгөхдөө заавал Jinhak Apply (진학어플라이) вэбсайтаас шуудангаар илгээх зориулалтын хавтас/шошгыг хэвлэж авч наан илгээх шаардлагатай.** |

## 2) 2 дугаар элсэлт

| Ангилал | **Өргөдөл хүлээн авах** | **Баримт бүрдүүлж өгөх** |
|---|---|---|
| Хугацаа | 2027.01.04. (Даваа) 10:00 ~ 2027.01.11. (Даваа) 17:00 | 2027.01.04. (Даваа) 10:00 ~ 2027.01.11. (Даваа) 17:00 |
| Бүртгэл хийх арга | Онлайн бүртгэл хийх | **Шуудангаар болон өөрийн биеэр ирж өгөх бол**<br>- Шуудангаар илгээсэн баримт зөвхөн бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө хүлээж авсан материалийг тооцно.<br>- Өөрийн биеэр ирж өгөх: Даваа~Баасан 10:00 ~ 17:00 (Үдийн цайны цагаар хүлээн авахгүй 12:00 ~ 13:00)<br>※ **Бичиг баримтаа заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.**<br>※ **Олон нийтийн амралтын өдөр материал хүлээж авахгүй** |
| Материал хүлээн авах газар | - Сургуулийн элсэлтийн бүртгэлийн цахим хуудас (https://ipsi.sungshin.ac.kr)<br>- Jinhak apply бүртгэлийн цахим хуудас (http://www.jinhakapply.com/) | Илгээх хаяг:<br>((03162) 서울시 종로구 인사동5길 25 하나로빌딩 10층 1007호<br>(03162) #1007, 10F, Hanaro Building, 25 Insadong 5-gil, Jongno-gu Seoul, Republic of Korea<br>(International Admissions Service Center)<br>**Анхаарах зүйл:**<br>**Баримт бичгийг өгөхдөө заавал Jinhak Apply (진학어플라이) вэбсайтаас шуудангаар илгээх зориулалтын хавтас/шошгыг хэвлэж авч наан илгээх шаардлагатай.** |

3) Чухал анхаарах зүйлс

- Зөвхөн 1 мэргэжлээр 1 удаа бүртгэл хийх боломжтой (Давхар өргөдөл гаргах боломжгүй).
- Бүрдүүлэх баримтыг заасан хугацааны дотор ирүүлээгүй тохиолдолд шаардлага хангаагүйд тооцогдож хасагдана.
- Бүрдүүлсэн баримтыг дарааллаар нь жагсааж хавсаргаад, баруун доод буланд нь овог нэр, бүрдүүлсэн баримтын нэрийг бичнэ.
  (Жишээ нь: Ким Сон Шинь, ахлах сургуулийн дүнгийн хуудас)
- Сургуульд элсэх өргөдөл, тавигдах шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах өргөдлийн хуудасны маягтыг сургуулийн цахим хуудаснаас татаж авна уу.

# 2. ӨРГӨДӨЛ ГАРГАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

1) Элсэлтийн өргөдөл гаргахын өмнө тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг заавал шалгана.
2) Бүртгүүлсэн анкет засах, бүртгэлийг цуцлах боломжгүй бөгөөд элсэлтийн хураамжийг буцааж олгохгүй.
3) Элсэлтийн хураамж буцаан олгох заавар
   - Дээд боловсролын тухай хууль」-н 34.4.5-д заасны дагуу элсэлтийн хураамжийн орлого·зарлагын тооцооноос үлдэгдэл гарсан тохиолдолд өргөдөл гаргагчийн төлсөн элсэлтийн хураамжийн мөнгөн дүнтэй харьцуулан өргөдөл гаргагчийн сонгосон дараахь аль нэг аргын дагуу буцааж олгоно.

> ■ Сургууль дээр өөрийн биеэр ирж авна.
> ■ Элсэлтийн анкетанд бичиж үлдээсэн дансаар хүлээн авна.

   - Буцаан олгох мөнгийг дансаар шилжүүлж авах аргыг сонгосон тохиолдолд банкны үйлчилгээний хураамжийг суутгасны дараа үлдэгдэл мөнгийг шилжүүлнэ. Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж нь буцаан олгох элсэлтийн хураамжны мөнгөн дүнгээс илүү гарсан тохиолдолд буцааж олгохгүй.

4) Зурганд тавигдах шаардлага

- Сүүлийн 3 сарын дотор авахуулсан иргэний үнэмлэхний зураг(өнгөт, 3cm×4cm) хавсаргана.
- Малгайтай, маск, нарны шил зүүсэн, засвар оруулан таних аргагүй болсон зураг, өөр хүний зураг хавсаргасан баримт хүлээж авахгүй.

5) Хувийн мэдээлэл авч, ашиглах

- Сургуульд элсэх өргөдөл гаргагчийн зөвшөөрлийн дагуу элсэлтийн бүртгэлд шаардлагатай хувийн мэдээллийг цуглуулж авна. Авсан хувийн мэдээллийг сургуулийн дотоод журмын дагуу зөвхөн элсэлт, сургалтын үйл ажиллагаанд ашиглах бөгөөд бусад зорилгоор ашиглахгүй.
- Авах хувийн мэдээлэл: Овог нэр, гадаад иргэний үнэмлэхний дугаар, төгссөн сургуулийн нэр, зураг, хаяг, гэрийн болон гар утасны дугаар, e-mail, элсэлтийн хураамж буцаан олгох дансны дугаар г.м

※ Алдаатай бөглөсөн, дутуу бүрдүүлсэн баримт

- Баримт буруу бөглөсөн, мэдээлэл орхигдуулсан, баримт дутуу бүрдүүлсэн, баримт хүлээн авах хугацаа хэтрүүлсний улмаас үүссэн асуудлын хариуцлагыг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.
- Элсэлтийн хугацаанд өгөх шаардлагатай мэдээллийг **өргөдөл гаргагчийн e-mail хаягаар илгээх** тул **e-mail хаягаа алдаагүй бичиж** үлдээнэ үү. **E-mail хаяг алдаатай бичигдсэний улмаас үүссэн асуудлын хариуцлагыг өргөдөл гаргагч** хүлээнэ.

## 3. ЭЛСЭЛТИЙН ХУРААМЖ

**1) Энгийн** тэнхим(анги): 150,000 вон

**2) Урлаг**·Биеийн тамирын тэнхим(анги): 170,000 вон

# V. БҮРДҮҮЛЭХ БАРИМТ

| Дугаар | Бүрдүүлэх баримтын жагсаалт | Шинэ элсэгч | Шилжин элсэгч | Бүрдүүлэх хэлбэр | Апостилийн гэрчилгээ / Консулын газрын гэрчилгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | ■ Элсэлтийн өргөдлийн анкет<br>- Онлайн бүртгэл хийсний дараа хэвлэж өгнө | O | O | Эх хувь | X |
| 2 | ■ Гадаад пасспортны хуулбар<br>- (Иргэншил болон цээж зураг гарсан хуудас) | O | O | Хуулбар | X |
| 3 | ■ Гадаад иргэний үнэмлэхний ард / урд хуулбар<br>(зөвхөн үнэмлэхтэй оюутануудад хамааралтай) | O | O | Хуулбар | X |
| 4 | ■ Албан ёсны хэлний оноо (TOPIK, IELTS, TOEFL, IBT)<br>- Бүртгэлийн хугацаа дуусах өдрөөс өдрөөс тооцон 2жилийн дотор авсан гэрчилгээ<br>- Үндэсний хэл нь англи хэлтэй орны иргэн хэлний гэрчилгээ өгөх шаардлагагүй<br>- Манай СОНШИН сургуулийн Солонгос хэлний бэлтгэлийн 4-р түвшнээс дээш төгсөгчид нь TOPIK оноогүйгээр элсэх тохиолдолд төгссөн сертификатын дээр ‘TOPIK 대체서류’ гэж гараараа бичиж өгнө | O | O | Эх хувь | X |
| 5 | ■ Ахлах сургуулийн дүнгийн хуудас, сургууль төгссөн(төгсөх гэж байгаа тухай тодорхойлолт) гэрчилгээ<br>- Солонгос ахлах сургууль : Эх хувь 1<br>- Хятад улсад сургууль төгссөн бол: Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох баримтыг заавал баталгаажуулна.<br>- Гадаад улсын сургууль: Заавал апостилийн гэрчилгээ эсвэл консулын газраар баталгаажуулна.<br><br>※ Англиас өөр хэл дээрх бичиг баримтийг зайлшгүй солонгос эсвэл англи хэл дээр орчуулж нотариатаар баталгаажуулах шаардлагатай. | O | X | Эх хувь | O |
| 6 | ■ Ахлах сургуулийн дүнгийн тодорхойлолт<br>- Солонгос ахлах сургууль: Бүх улиралын дүн гарсан тодорхойлолт<br>- Гадаад ахлах сургууль : Бүх улиралын дүн гарсан тодорхойлолтын апостилийн гэрчилгээ эсвэл консулын газраар баталгаажуулна.<br><br>※ Сургуулийн дүнгийн хуулбарыг нэг семестер эсвэл нэг хичээлийн жилээр гаргаж өгөх ёстой. (Онооны хувь эсвэл дээд онооны шалгуурыг тодорхой бичсэн байх)<br>※ Англиас өөр хэл дээрх бичиг баримтийг зайлшгүй солонгос эсвэл англи хэл дээр орчуулж нотариатаар баталгаажуулах шаардлагатай. | O | X | Эх хувь | O |
| 7 | ■ Өмнөх их сургууль коллеж төгссөн гэрчилгээ<br>- Солонгосын их дээд сургуулиуд: Их сургуулиа төгссөн/төгссөн тухай (хүлээгдэж буй) гэрчилгээг эх хувиар илгээх<br>- БНХАУ-ын их дээд сургуулиуд: Боловсролын гэрчилгээг ирүүлэх шаардлагатай ("БНХАУ-ын сургууль төгсөгчдийн эрдэм шинжилгээний бичиг хүлээн зөвшөөрөх гарын авлага"-ыг 17-р хуудаснаас үзнэ үү)<br>- БНХАУ-аас бусад гадаадын их дээд сургуулиуд: Их сургуулийг төгссөн тухай:(хүлээгдэж буй) гэрчилгээг апостиль эсвэл консулын газраар баталгаажуулна. | X | O | Эх хувь | O |
| 8 | ■ Өмнөх их сургуулийн дүнгийн хуулбар<br>- Солонгосын их дээд сургуулиуд: Бүх улирлын дүнг агуулсан их сургуулийн дүнгийн тодорхойлолтыг эх хувийг ирүүлнэ<br>- Гадаадын их, дээд сургууль: Бүх улирлын дүнг агуулсан их сургуулийн дүнгийн хуулбарыг апостиль эсвэл консулын газраар баталгаажуулна.<br>※ Сургуулийн дүнгийн хуулбарыг нэг семестер эсвэл нэг хичээлийн жилээр гаргаж өгөх ёстой. (Онооны хувь эсвэл дээд онооны шалгуурыг тодорхой бичсэн байх) | X | O | Эх хувь | O |
| 9 | ■ Өөрийн болон эцэг эхийн төрөл садангийн тодорхойлолт<br>Иргэний харъяалал, төрөл садангийн лавлагаа<br>· Хятад: Өрхийн ам бүлийн бүртгэл, ураг төрлийн тодорхойлолт (Өргөдөл гаргагч болон эцэг эх тусдаа ам бүлийн бүртгэлтэй бол бүгдийг нь бүрдүүлж өгнө)<br>· Вьетнам: Өрхийн ам бүлийн тодорхойлолт(Ам бүлийн бүртгэл(So Ho Khau)), төрсний гэрчилгээ(Giay khai sinh)<br>· Монгол:: Төрөл садны лавлагаа<br>· Узбекстан, Киргизстан, Казахстан, Украин, Тайланд: Төрсний гэрчилгээ<br>· Мьянмар: Өрхийн ам бүлийн тодорхойлолт<br>· Филиппин: Family Census<br>· Индонез: Өрхийн ам бүлийн тодорхойлолт(KARTU | O | O | Эх хувь | X |

<table>
<tr><td></td><td>KELUARGA)<br><br>※ Англиас өөр хэл дээрх бичиг баримтийг зайлшгүй солонгос эсвэл англи хэл дээр орчуулж нотариатаар баталгаажуулах шаардлагатай.<br>※ Эцэг эх нь салсан, дахин гэрлэсэн, нас барсан бол холбогдох баримтыг бүрдүүлж хавсаргана.<br>Жишээ нь) Гэрлэлт цуцалсан тодорхойлолт, гэрлээгүй ганц бие болохыг нотлох баримт, ганцаараа хүүхэд өсгөсөн эцэг эхийн тодорхойлолт, нас барсны гэрчилгээ зэрэг</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>10</td><td>■ Эцэг эхийн гадаад пасспортний хуулбар<br>- Эцэг эхийн гадаад пасспорт байхгүй тохиолдолд тухайн улсын иргэний үнэмлэхний хуулбар<br><br>※ Англиас өөр хэл дээрх бичиг баримтийг зайлшгүй солонгос эсвэл англи хэл дээр орчуулж нотариатаар баталгаажуулах шаардлагатай.</td><td>O</td><td>O</td><td>Хуулбар</td><td>X</td></tr>
<tr><td>11</td><td>■ Дансны үлдэгдлийн тодорхойлолт : Тэнцэгчдийн нэрсийн жагсаалтыг зарласаны дараа зөвхөн тэнцсэн оюутнууд хураалгана. ( Хураалгах хугацаа : 1 болон 2 дахь элсэлтийн сургалтын төлбөрөө төлсний дараа нэн даруй өгнө.<br>- 20,000,000 воноос дээш үлдэгдэлтэй дансны тодорхойлолт<br>- Дансны үлдэгдэлийг сургуульд элсэн орох өдөр хүртэл байршуулах<br>- Өөрийн нэр дээрх дансны хуулга байх ёстой бөгөөд онцгой тохиолдолд зөвхөн эцэг эхийн нэр дээрх дансыг зөвшөөрнө<br><br><table><tr><th>Улс</th><th>Агуулга</th></tr><tr><td>Хятад</td><td>Визийн хүсэлт (солилт) гаргасnаас хойш 30 хоногийн дотор олгогдсон үндсэн хувилбар л хүлээн зөвшөөрөгдөх"</td></tr><tr><td>Вьетнам</td><td>Тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа солонгосын банк санхүүгийн байгууллага эсвэл заагдсан орон нутгийн банкнаас (Vietinbank, Vietcombank, Agribank, Techcombank) олгосон дансны үлдэгдлийн тодорхойлолт</td></tr><tr><td>Узбекстан</td><td>Зөвхөн KDB (Солонгосын Хөгжлийн Банк)-ны дансны үлдэгдлийн тодорхойлолт хүлээн авна</td></tr></table><br>- Жич, гадаад иргэний бүртгэл хийлгээд солонгост оршин сууж байгаа иргэд солонгос дахь өөрийн нэрийн дансны тодорхойлолтыг зайлшгүй шаардана. (Шаардлагатай гэж үзвэл гадаад гуйвуулгын лавлагаа бүрдүүлж өгөхийг шаардана)<br>※ Нэмэлт лавлагаа шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эцэг эхийн санхүүгийн чадварыг нотлох баримт бүрдүүлж өгөхийг шаардана.<br>· Ажил хөдөлмөр эрхэлдэг бол: Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын хураамж төлснийг нотлох баримт г.м<br>· Хувиараа аж ахуй эрхлэгч: Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сүүлийн 6 сарын гүйлгээний хуулга г.м<br>· Бусад: Тэтгэвэр авагчийн лавлагаа г.м</td><td>O</td><td>O</td><td>Эх хувь</td><td>X</td></tr>
<tr><td>12</td><td>■ Боловсролын зэрэг / суралцсан байдал шалгахыг зөвшөөрсөн зөвшөөрлийн хуудас</td><td>O</td><td>O</td><td>Эх хувь</td><td>X</td></tr>
<tr><td>13</td><td>■ Өөрийн танилцуулга болон суралцах төлөвлөгөө<br>- Англи эсвэл Солонгос хэлээр бичнэ.<br>- Онлайн бүртгэл хийсний дараа хэвлэж өгнө</td><td>O</td><td>O</td><td>Эх хувь</td><td>X</td></tr>
<tr><td>14</td><td>■ Гадаадад суралцах зардал хариуцах амлалт (санхүүгийн батлан даагч)<br>- Сургуулийн тусгай маягт<br>※ Нэг оюутанд зөвхөн нэг санхүүгийн батлан даагч байж болох ба тухайн оюутан өөрөө өөрийнхөө батлан даагч байж болохгүй</td><td>O</td><td>O</td><td>Эх хувь</td><td>X</td></tr>
<tr><td>15</td><td>■ Хэлний бэлтгэлд суралцсан тодорхойлолт, дүнгийн тодорхойлолт (зөвхөн солонгост хэлний бэлтгэлд сурсан оюутан хамааралтай)<br>- Соншин эмэгтэйчүүдийн их сургуулийн оюутан мөн адил бүрдүүлнэ</td><td>O</td><td>O</td><td>Эх хувь</td><td>X</td></tr>
<tr><td>16</td><td>■ Бусад нэмэлт баримт бичиг (нэмэлтээр өгөх хүсэлтэй хүмүүст хамааралтай)<br>- Дотоодын их, дээд сургуулийн хэлний бэлтгэлийн ирц, дүн, төгссөн гэрчилгээ гэх мэт.<br>- Тухайн улсдаа их дээд сургуулийн элсэлтийн шалгалтын онооны гэрчилгээ эсвэл төгссөн гэрчилгээ (SAT, A-LEVEL, IB, 高考 гэх мэт)<br>- Бусад албан ёсны хэлний оноо (TOEIC, HSK, JLPT, DELF, DELE, TestDaF гэх мэт)<br>- Ахлах сургуулийн бусад шагнал, гэрчилгээ гэх мэт.<br><br>※ Англиас өөр хэл дээрх бичиг баримтийг зайлшгүй солонгос эсвэл англи хэл дээр орчуулж нотариатаар баталгаажуулах шаардлагатай.</td><td>O</td><td>O</td><td>Эх хувь</td><td>X</td></tr>
</table>

□ **Баримт бүрдүүлж өгөхөд анхаарах зүйлс**

1. Бүх баримтын эх хувийг бүрдүүлж өгнө. Хуулбар ирүүлсэн тохиолдолд эцсийн хариу гарснаас хойш 2027.02.19.(Баасан)-ны дотор заавал баримтын эх хувийг ирүүлнэ.
   ※ Эх хувийн олгосон огноо: Өргөдөл (материал) хүлээн авч эхлэх өдрөөс хойш 3 сарын дотор байхыг зөвлөж байна.
2. Англи хэлнээс бусад хэл дээр боловсруулагдсан баримтыг заавал орчуулан, нотариатаар баталгаажуулна.
   ※ Англи хэлнээс бусад хэл дээр боловсруулагдсан баримтыг орчуулан, нотариатаар баталгаажуулах явцад гарсан орчуулгын алдаанаас үүдэлтэй асуудлыг өргөдөл гаргагч хариуцна.
3. Гадаад улсын сургууль, байгууллагаас гаргасан бүх баримт бичгийг тухайн улсад суугаа БНСУ-ын элчин сайдын яамны ‘Консулын газраар баталгаажуулалт’ хийлгэнэ. Апостилийн гэрээнд нэгдсэн улсын иргэд тухай улсын холбогдох байгууллагаас ‘Апостилийн гэрчилгээ’ гаргуулан хавсаргана.
4. Сургуулиа төгсөх гэж байгаа иргэд өргөдлийн эцсийн хариу гарсны дараа сургууль төгссөн гэрчилгээг заавал бүрдүүлж өгнө. Төгсөлтийн гэрчилгээнд мөн адил ‘Апостилийн гэрчилгээ’ гаргуулах юмуу ‘Гадаад улсын боловсролын байгууллага’ болон ‘Консулын газар’-аар баталгаажуулалт хийлгэж хавсаргана.
5. Бүрдүүлж өгсөн баримтан дээрхи овог нэр зөрсөн тохиолдолд нэг хүн гэдгийг нотлох баримт(Тухайн улсын шүүх байгууллага, дипломат төлөөлөгчийн газраас гаргуулсан)-ыг заавал хавсаргана.
6. Бичиг баримт хуурамч эсэхийг шалгах шаардлага гарсан тохиолдолд нэмэлт баримт бүрдүүлж ирэхийг шаардаж болно(Тухайн улс дахь БНСУ-ын банк санхүүгийн байгууллагаас гаргуулсан банкны үлдэгдлийн тодорхойлолт г.м).
7. Бүрдүүлж өгсөн бүх баримтыг буцааж олгохгүй.
8. Хуурамч баримт бүрдүүлсэн, тавигдах шаардлагыг хангаагүй, ярилцлаганд өөр хүн оруулсан нь илэрсэн тохиолдолд шалгаруулалт, сургуульд тэнцсэн хариуг хүчингүй болгоно.

□ **Хятад улсад сургууль төгсөгчдийн эзэмшсэн боловсролын түвшинг нотлох баримт бүрдүүлэх тухай**

1. ШИНЭ ЭЛСЭГЧ

А. Энгийн сургалттай ахлах сургууль: БНХАУ-ын боловсролын яамны харъяа боловсролын түвшин·зэрэг баталгаажуулах төвөөс гаргуулсан баталгаат лавлагаа(Verification Report)

Б. БНХАУ-ын боловсролын яамны харъяа боловсролын түвшин·зэрэг баталгаажуулах төв(CHSI)-өөс боловсролын зэргийн лавлагаа гаргуулах боломжгүй техник мэргэжлийн дунд сургууль **төгсөгчид** (батлан итгэмжлэгдсэн сургууль төгсөгчдөд хамаарна) дараахь заалтын дагуу баримт бүрдүүлж өгнө.

| Ангилал | | Сонгон шалгаруулалт явуулах үндэслэл | Тайлбар |
|---|---|---|---|
| **Техник мэргэжлийн дунд сургууль** | **Энгийн сургалттай техник мэргэжлийн дунд сургууль (普通中专)** Regular Specialized Secondary Schools<br>**Техник мэргэжлийн ахлах сургууль(职业高中)** Vocational High Schools<br>**Насанд хүрэгчдэд зориулсан техник мэргэжлийн сургууль (成人中专)** Adult Specialized Secondary Schools | **① Онлайнаар гаргуулсан баримт**<br>i) Орон нутгийн боловсролын дээд байгууллагаас гаргасан сургууль төгссөн гэрчилгээ<br>* БНХАУ дахь БНСУ-ын Консулын газрын баталгаажуулалт эсвэл Апостиль гэрчилгээ (Apostille).<br>* Онлайнаар бүрдүүлсэн баримтын хуурамч эсэхийг шалгах боломжтой тохиолдолд зөвхөн хүлээж авна.<br>**② Оффлайнаар гаргуулсан баримт: ‘Сургуулийн мэдээллийн лавлагаа(Тус сургуулийн маягт)’-г заавал бүрдүүлж өгнө**<br>i) Орон нутгийн боловсролын дээд байгууллагаас гаргасан сургууль төгссөн гэрчилгээ: БНХАУ дахь БНСУ-ын Консулын газрын баталгаажуулалт эсвэл Апостиль гэрчилгээ (Apostille).<br>ii) Тухайн сургуулиас олгосон төгсөлтийн гэрчилгээ: Боловсролын төв(хотын боловсролын газар) + БНХАУ дахь БНСУ-ын Консулын газрын баталгаажуулалт эсвэл Апостиль гэрчилгээ (Apostille). | 1-ийг нь сонгоно |
| | **Үйлдвэрлэлийн техниологийн сургууль (技工学校)** Skilled Workers Schools | **Хүний нөөц, нийгмийн хамгааллын яамны албан ёсны цахим хуудас (www.mohrss.gov.cn) -наас авсан хувь***<br>**+ БНХАУ дахь БНСУ-ын Консулын газрын баталгаажуулалт эсвэл Апостиль гэрчилгээ (Apostille).**<br>* Онлайнаар бүрдүүлсэн баримтын хуурамч эсэхийг шалгах боломжтой тохиолдолд зөвхөн хүлээж авна. | |
| **Бусад магадлан итгэмжлэгдсэн ахлах сургууль** | | **Тухайн сургуулиас олгосон төгсөлтийн гэрчилгээ + БНХАУ дахь БНСУ-ын Консулын газрын баталгаажуулалт эсвэл Апостиль гэрчилгээ (Apostille).**<br>※ **Сургууль байгуулахыг зөвшөөрсөн гэрчилгээ**(Харъяа хуулийн этгээдийн гэрчилгээ(事业单位法人证书) болон хувийн сургуулийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн гэрчилгээ(民办学校办学许可证))-ний **хуулбарыг заавал хавсаргана**(Жич, Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн баримтыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй) | |

2. ШИЛЖИН СУРАЛЦАГЧ: Коллеж болон түүнээс дээш боловсролын диплом, эрдмийн зэрэгтэй холбоотой баталгаат төвөөс гаргасан баталгаажуулалтын тайланг ирүүлнэ.
※ Олгох газар: БНХАУ-ын Боловсролын яамны удирддаг эрдмийн зэрэгтэй холбоотой баталгаат төв (http://chsi.com.cn), Сөүлийн Күнзийн институт (https://renew.kongzi.co.kr/)

# VI. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ХЭЛБЭР БА АРГА

## 1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

| Материал шалгаруулалт | Тайлбар |
|---|---|
| 100% | Шаардлагатай тохиолдолд зарим оюутнаас ярилцлага эсвэд шалгалт авна |

## 2. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ АРГА

1. Баримт бичгийг шалгах арга: Оюутны академийн чадавхи, ирээдүйн чиг баримжаа, хамтын нийгмийн хариуцлага гэсэн 3 үндсэн үнэлгээний үзүүлэлтээр, тэдгээрийг нийтээр нь болон гүнзгий үнэлж, шалгаруулна.
2. Элсэлтийн шалгуур тус бүрийн үнэлгээний дагуу оноог нэгтгэн элсэлтийн тэнхим, мэргэжэл зэргийн дүнгийн үнэлгээгээр шалгаруулна.
3. Адил оноогоор тэнцсэн тохиолдолд сургуулийн дотоод журмын дагуу байр эзлүүлэх болно.
4. Хэрэв суралцах чадвар болон санхүүгийн байдал нь тохиромжгүй гэж үзвэл элсэхийг зөвшөөрөхгүй байх боломжтой.
5. Элссэн оюутны сургалтын мэдээлэл болон бусад баримт нь үнэн зөв бус эсвэл шаардлага хангахгүй бол элсэлтийг цуцалж болох юм.
6. Тохиромжгүй хүмүүс, баримт бичгээ бүрдүүлээгүй хүмүүс, худал мэдээлэл өгсөн болон баримт бичиг шилжүүлсэн, хуурамч үйлдэл хийсэн, эсвэл бусад хуурамч үйл ажиллагаанд оролцсон хүмүүс элсэлтийг цуцалж болох юм.

# VII. АНХААРАХ ЗҮЙЛС

## 1. ӨРГӨДӨЛ ГАРГАГЧДЫН АНХААРАХ ЗҮЙЛС

1) Сургуульд тэнцсэн эсэх хариуг хувь хүнрүү явуулахгүй ба сургуулийн вэб хуудаснаас шалгах ёстой.
2) Элсэлтийн хүсэлт гаргасан хуудсан дээр элсэлтийн хугацааны турш элсэгчтэй холбоо барих боломтжой утас болон гэрийн хаяг зэргийг заавал бичих ёстой ба, алдаатай бичих болон холбоо барих боломжгүй байсан зэрэг асуудлаас үүссэн элсэгчид гарсан хохиролыг сургуулийн зүгээс шийдэж өгөх боломжгүй гэдгийг анхаарна уу. (Заавал хүчинтэй имэйл хаяг утасны дугаараа бичихийг анхааруулъя.)
3) Энэхүү элсэлт авах журамд ороогүй бусад асуудлыг тус сургуулийн элсэлтийн комиссын хурлын шийдвэрийн дагуу тусад нь хэрэгжүүлнэ.
4) Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл элсэлтийн бүртгэлийн хэлтэст хандана уу.

Tel: 02-920-7994 Цахим хуудас: https://ipsi.sungshin.ac.kr E-mail: intadmission@sungshin.ac.kr

## 2. СУРГАЛТЫН ТӨЛБӨР ТӨЛӨХ АРГА, АНХААРАХ ЗҮЙЛС

1) СУРГАЛТЫН ТӨЛБӨР ТӨЛӨХ ЗААВАР

| Ангилал | Сургалтын төлбөр төлөх заавар | |
|---|---|---|
| | 1 дүгээр элсэлт | 2 дүгээр элсэлт |
| Төлбөрийн нэхэмжлэлийн хуудас хэвлэж авах | 2026.12.30. (Лхагва) ~ 2027.01.06 (Лхагва) | 2027.01.27. (Лхагва) ~ 2027.01.29 (Баасан) |
| | Элсэлтийн бүртгэлийн цахим хуудаснаас хэвлэж авна. | |
| Төлбөр хийх хугацаа | 2026.12.30. (Лхагва) ~ 2027.01.06 (Лхагва) | 2027.01.27. (Лхагва) ~ 2027.01.29 (Баасан) |
| Төлбөрийн хэмжээ | Сургалтын төлбөрийн мөнгөн дүн | |
| Төлбөр хийх банк | Төлбөр төлөх зааварыг тус бүрд нь мэдээллэх болно. | |

2) Сургалтын төлбөр төлөөгүй элсэгчийн бүртгэл цуцлагдана.
3) Бүрдүүлсэн баримтын эх хувийг хүргүүлсэн, сургалтын төлбөр бүрэн төлсөн дараалаар виз гаргуулахад шаардлагатай “Сургуульд элсэх зөвшөөрлийн стандарт хуудас”-ыг гаргаж өгнө. Материал заасан хугацаанаас хоцорсон, дутуу бүрдүүлсний улмаас үүссэн асуудлыг өргөдөл гаргагч өөрөө хариуцна гэдгийг анхаарна уу.
4) Бүрдүүлсэн материалд худал мэдээлэл оруулсан, өөрчилсөн нь илэрсэн тохиолдолд сургуульд элссэний дараа ч гэсэн элсэлтийг цуцлана. Иймэ тохиолдолд урьдчилан төлсөн элсэлтийн хураамж, сургалтын төлбөр зэрэг бусад мөнгөн төлбөрийг буцааж олгохгүй.
5) Хууль бус арга хэрэглэсний улмаас тус сургууль болон бусад сургуулийн элсэлтийг цуцлах арга хэмжээ авахуулагдсан хүн элсэлт цуцлагдсан өдрөөс хойш 3 жилийн дотор тус сургуульд элсэх өргөдөл гаргах эрхгүй.

## 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ

1) Сургуульд элссэний дараа эрүүл мэндийн үзлэгт хамрагдана. Дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
2) Өөрт байгаа өвчин эмгэг, биед учрах саад бэрхшээлийн улмаас үүсэх магадлалтай хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс ирээдүйн мэргэжлээ сайтар тунгаан бодож сонгоно уу.

## 4. ГАДААД ОЮУТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛд хамрагдах тухай заавар

「Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль」 болон 「Тус хуулийг хэрэгжүүлэх журам」-ын дагуу 2021 оны 3 дугаар сараас эхлэн гадаад оюутнууд бусад гадаадын иргэдийн нэгэн адил Үндэсний эрүүл мэндийн даатгалын орон нутгийн даатгуулагчийн ангилалд зайлшгүй хамрагдана.

# VIII. ТЭТГЭЛЭГ

**Элсэлтийн эхний улиралд олгогдох тэтгэлэг нь сургалтын төлбөрийн нэхэмжлэл дээр урьдчилан хасагдахгүй бөгөөд оюутан сургалтын төлбөрөө бүрэн төлсний дараа эхний улирлын хугацаанд буцаан олгогдоно.**

## 1. ГАДААД ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТЭТГЭЛЭГ

### A. Олон улсын тэнхим

| Тэтгэмжийн ангилал | | Олгох үндэслэл | | Тэтгэлэг олгогдох журам | Тэтгэлэг олгогдох хугацаа | |
|---|---|---|---|---|---|---|
| Тэтгэлэг олгох хүрээ | Тэтгэмжийн нэр | Солонгос хэл дээрх анги | Англи хэл дээрх анги | | | |
| **Шинэ элсэгч** | Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-1 | - | Англи хэлний чиглэлийн элсэлтийн шаардлагыг хангасан тохиолдолд | Эхний улирлын 100% | 60% | Элссэн улирал |
| | | | | | 40% | Төгсөх улирал* |
| **3курсийн шилжин элсэгч** | Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-3 | * TOPIK 4 болон түүнээс дээш | Англи хэлний чиглэлийн элсэлтийн шаардлагыг хангасан тохиолдолд | Эхний улирлын 60% | Элссэн улирал | |
| | Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-5 | * TOPIK 3 | - | Эхний улирлын 40% | | |
| **4курсийн шилжин элсэгч** | Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-5 | * TOPIK 4 болон түүнээс дээш | Англи хэлний чиглэлийн элсэлтийн шаардлагыг хангасан тохиолдолд | Эхний улирлын 40% | Элссэн улирал | |
| | Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-6 | * TOPIK 3 | - | Эхний улирлын 30% | | |

※ *Төгсөх улиралд олгогдох тэтгэлэг нь 8дахь улиралд сургалтын нэмэлт тэтгэлэг байдлаар олгогдоно.

### B. Бусад тэнхим

| Тэтгэмжийн нэр | Олгох үндэслэл | | Олгох хувь | Тэтгэлэг олгогдох хугацаа |
|---|---|---|---|---|
| | Шинээр элсэгч, 3-р курсэд шилжиж орсон оюутан | 4-р курсэд шилжиж орсон оюутан | | |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-1 | * TOPIK 6 | - | Эхний улирлын 100% | Элссэн улирал |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-2 | * TOPIK 5 | - | Эхний улирлын 80% | |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-3 | * TOPIK 4 | - | Эхний улирлын 60% | |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-4 | | * TOPIK 5 | Эхний улирлын 50% | |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-5 | * TOPIK-н шалгалтны 3-р зэрэг | * TOPIK 4<br>* Тус сургуулийн “Олон улсын боловсролын төв”-ийн солонгос хэлний бэлтгэл сургалтны 1-ооc дээш улирлын хичээлд хамрагдсан(төгсөх гэж байгаа) болон 3-р шатны сургалтанд хамрагдсан (төгсөх гэж байгаа) хүн | Эхний улирлын 40% | |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-6 | - | * TOPIK 3 | Эхний улирлын 30% | |
| Гадаад оюутны төлбөрийн хөнгөлөлт-7 | * TOPIK 2<br>* Өөр их сургуулийн хэлний бэлтгэл сургалтны 3-с дээш шатны сургалтанд хамрагдсан (төгсөх гэж байгаа) хүн | * TOPIK 2<br>* Өөр их сургуулийн солонгос хэлний бэлтгэл сургалтны 3-с дээш шатны сургалтанд хамрагдсан (төгсөх гэж байгаа) хүн | Эхний улирлын 20% | |

### С. Соншин эмэгтэйчүүдийн их сургуулийн хэлний бэлтгэлийг төгссөн оюутанд олгох тэтгэлэг

1. Тэтгэлэгийн нэр : Гадаад иргэний төлбөрийн хөнгөлөлт (Соншин их сургуульдаа элсэх тэтгэлэг)
2. Тэтгэлэг олгох байдал : **Хичээлийн эхний улиралын төлбөр 100% хөнгөлөлт**
3. Тэтгэлэг олгох хугацаа : Элсэж орсон эхний улирал
4. Тэтгэлэг олгох нөхцөл : Соншин эмэгтэйчүүдийн их сургуулийн хэлний бэлтгэлд 2 улиралаас дээш хугацаанд суралцсан, 4дүгээр түвшинээс дээш түвшин төгссөн болон, төгсөх гэж буй оюутан. Олон улсын боловсролын төвийн даргын тусгай бичиг аван, манай сургуулийн баклавр зэрэгт шинээр элсэж буй болон 3дугаар курсээс шилжин орж буй оюутан.

## 2. ГАДААД ОЮУТНУУДАД ОЛГОХ ДҮНГИЙН ТЭТГЭЛЭГ (ОЛГОХ ХУГАЦАА: АНХ ЭЛССЭН ХИЧЭЭЛИЙН УЛИРЛААС БУСАД ХИЧЭЭЛИЙН УЛИРАЛД)

### А. Олон улсын тэнхим

| Тэтгэмжийн нэр | Олгох үндэслэл | Олгох хувь |
|---|---|---|
| Гадаад оюутны сурлагын дүн-1 | Өмнөх семестрийн мэргэжил болон курс тус бүрийн шилдэг 2% -т жагссан оюутнууд | Хичээлийн төлбөрийн 100% |
| Гадаад оюутны сурлагын дүн-2 | Өмнөх семестрийн мэргэжил болон курс тус бүрийн шилдэг 5% -т жагссан оюутнууд | Хичээлийн төлбөрийн 80% |
| Гадаад оюутны сурлагын дүн-3 | Өмнөх семестрийн мэргэжил болон курс тус бүрийн шилдэг 10% -т жагссан оюутнууд | Хичээлийн төлбөрийн 60% |
| Гадаад оюутны сурлагын дүн-4 | Өмнөх семестрийн мэргэжил болон курс тус бүрийн шилдэг 20% -т жагссан оюутнууд | Хичээлийн төлбөрийн 40% |
| Гадаад оюутны сурлагын дүн-5 | Өмнөх семестрийн мэргэжил болон курс тус бүрийн шилдэг 50% -т жагссан оюутнууд | Хичээлийн төлбөрийн 20% |

※ Өмнөх улиралд доод тал нь 12 кредит авсан байна.

### В. Бусад тэнхим

| Тэтгэмжийн нэр | Олгох үндэслэл | | Олгох хувь |
|---|---|---|---|
| | TOPIK-н шалгалтны 3-аас доош зэрэг | TOPIK-н шалгалтны 4-өөс дээш зэрэг | |
| Гадаад оюутны сурлагын дүн-1 | - | Өмнөх хичээлийн улиралд 4.3-с дээш | Хичээлийн төлбөрийн 100% |
| Гадаад оюутны сурлагын дүн-2 | Өмнөх хичээлийн улиралд 4.3-с дээш | Өмнөх хичээлийн улиралд 4.0-с дээш ~ 4.3-аас бага | Хичээлийн төлбөрийн 80% |
| Гадаад оюутны сурлагын дүн-3 | Өмнөх хичээлийн улиралд 4.0-с дээш ~ 4.3-аас бага | Өмнөх хичээлийн улиралд 3.5-с дээш ~ 4.0-аас бага | Хичээлийн төлбөрийн 60% |
| Гадаад оюутны сурлагын дүн-4 | Өмнөх хичээлийн улиралд 3.5-с дээш ~ 4.0-аас бага | Өмнөх хичээлийн улиралд 3.0-с дээш ~ 3.5-аас бага | Хичээлийн төлбөрийн 40% |
| Гадаад оюутны сурлагын дүн-5 | Өмнөх хичээлийн улиралд 3.0-с дээш ~ 3.5-аас бага | Өмнөх хичээлийн улиралд 2.5-с дээш ~ 3.0-аас бага | Хичээлийн төлбөрийн 20% |

※ Өмнөх улиралд доод тал нь 12 кредит авсан байна.

## 3. БУСАД ТЭТГЭЛЭГ (ОЛГОХ ХУГАЦАА: ХИЧЭЭЛИЙН УЛИРАЛД)

<table>
<tr><th>Тэтгэмжийн нэр</th><th>Олгох үндэслэл</th><th>Олгох хувь</th></tr>
<tr><td>Хичээлдээ идэвхи чармайлттай сурч байгаа гадаад оюутны тэтгэмж</td><td>Ахуйн хүнд нөхцөл байдлыг нь харгалзан тэнхимээс нэр дэвшүүлсэн гадаад оюутан</td><td rowspan="2">Амьжиргааны зардал</td></tr>
<tr><td>Global Plus тэтгэмж</td><td>Сургуулийн олон улсын харилцааны хөтөлбөр болон сургуулиас зохион байгуулдаг үйл ажиллагаанд идэхвхитэй оролцдог хэмээн тэнхимээс нэр дэвшүүлсэн гадаад оюутан
<table>
<tr><th>Ангилал</th><th>Агуулга</th></tr>
<tr><td>Global friends (Tutoring) хөтөлбөрт хамрагдсан</td><td>Солонгос оюутанд өөрийн эх хэлийг заах хөтөлбөрт бүрэн хамрагдсан, тавигдах шаардлагыг хангаж байгаа оюутнуудад олгоно(1 хичээлийн улиралд дор хаяж 10 удаа хөтөлбөрт оролцсон).</td></tr>
<tr><td>Global plus тэтгэлэгт хамрагдах оюутны хөтөлбөр</td><td>Global plus хөтөлбөрт оролцох оюутны сонгон шалгаруулалтанд тэнцэн хичээлийн нэг улирлын хугацаанд “Олон улсын хамтын ажиллагааны хэлтэс”-ийн төрөл бүрийн хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцсон дэмжлэг үзүүлсэн цагийн дагуу автоматаар олгодог.</td></tr>
</table></td></tr>
</table>

※ Сургалтын тэтгэмжийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг оюутанд дэмжлэг үзүүлэх хэлтэс(Tel. 02-920-7012)-ээс лавлана уу.

# 4. БУСАД ДЭМЖЛЭГ

## ■ Sungshin Global Friends

(BUDDY)

Гадаад оюутнуудыг солонгос ахуйд дасахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр. Тус сургуулийн BUDDY хөтөлбөрт хамрагдаж байгаа солонгос оюутнууд гадаад оюутнуудыг сургууль болон солонгос ахуйд дасахад нь дэмжлэг үзүүлдэг.

(Tutoring)

Гадаад оюутнууд өөрийн төрөлх эх хэл, соёлыг зааж өгдөг соёлын харилцааны Tutoring хөтөлбөр. Tutoring хөтөлбөрт хамрагдах хугацаанд тавигдсан шаардлагыг хангасан оюутнууд Global plus тэтгэмжид хамрагдах боломжтой.

(Мэргэжлийн менторинг)
Шинэ болон шилжин ирсэн гадаад оюутнууд (мент) нь тус сургуулийн хамтран суралцаж байгаа оюутнуу д (ментор)тай баг болон хамтран ажиллан, менторууд нь гадаад оюутнуудад академийн болон амьдралын адаптацийг дэмжиж, мэргэжлийн мэдлэгээ хуваалцах менторинг хөтөлбөр юм.

## ■ Олон улсын оюутны семинар

Сургууль бүрийн эхэнд, шинэ болон шилжин ирсэн гадаад оюутнуудад зориулсан олон улсын оюутны семинар зохион байгуулагдаж, сургуулийн танилцуулга, багийн үйл ажиллагаа, тоглоом, спортын үйл ажиллагаа зэрэг янз бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сургуультайгаа танилцахад тусална

## ■ Олон улсын солилцооны шөнө

Соншин глобал фрэндс (бадди, тьюторинг, мэргэжлийн менторинг) хөтөлбөрт оролцогч дотоод болон гадаад оюутнуудад зориулсан олон улсын солилцооны шөнө арга хэмжээ зохион байгуулагдаж, янз бүрийн улс орнууд болон соёлд ээлтэй, хамтран амьдрах соёлын уур амьсгалыг бүрдүүлж, оролцогчдын хоорондын харилцааг өргөжүүлэх боломжийг олгоно.

## ■ Соншин Глобал Фестиваль

Янз бүрийн орны соёлын үзэсгэлэн болон урлагийн тоглолт зэргийг зохион байгуулж, дотоод болон гадаад оюутнуудад сүлжээ байгуулах боломж олгоно.

## ■ Спортын наадам

Өмнөд Солонгосын орчин үеийн спортын наадмын соёлыг туршиж, хамтын ажиллагаа, нөхөрлөлийг хөгжүүлэх, оюутнуудын хоорондын холбоог бэхжүүлэх зорилготой.

## ■ Солонгос соёлын танилцах хөтөлбөр

Хичээлийн улирал тутамд 1~2 удаа гадаад оюутнуудад зориулсан төрөл бүрийн солонгос соёлын танилцах хөтөлбөр зохион байгуулагддаг.

## ■ Төгсгөлийн арга хэмжээ

Бүх гадаад оюутнуудад зориулсан жилийн төгсгөлийн арга хэмжээг зохион байгуулж, жилийн хугацаанд сургуулийн сурлага болон Солонгосын амьдралын талаар мэдээлэл солилцох боломжийг олгоно.

## ■ Олон улсын оюутны холбоо

Солонгос болон гадаад оюутнуудтай хамтран байгуулсан олон улсын оюутны холбоо нь дотоод болон гадаад оюутнуудын хэрэгцээг харгалзан шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг төлөвлөж, зохион байгуулдаг. Энэ холбоо нь гадаад оюутнуудад хэрэгтэй олон төрлийн арга хэмжээ, харилцаа холбооны үүргийг гүйцэтгэж, дэлхийн соёлын солилцоо, оюутны амьдрал, сургалт, карьер болон ажлын хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг.

## ■ TOPIK шалгалтанд бэлдэхэд үзүүлэх дэмжлэг

Гадаад оюутнуудын солонгос хэлний чадварыг дээшлүүлэх зорилгоор жилд 1 удаа TOPIK-ийн шалгалтны төлбөрийн дэмжлэг үзүүлдэг.

## ■ Эрүүл мэндийн үзлэг

Гадаад оюутнуудыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт төлбөргүй хамруулна.

## ■ Төрөл бүрийн сургалтын хөтөлбөр

Гадаад оюутнуудын аюулгүй байдлыг хангах, амжилттай суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн сургалтын хөтөлбөр зохион байгуулдаг.

(Цагаачлалын тухай хууль, гадаад оюутнуудад зориулсан тусгай сургалт, компьютер, галын аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт)

## ■ Гадаад харилцааны хэлтсийн гадаад оюутнуудад үзүүлэх дэмжлэг

Хичээл, сурлага, ахуй амьжиргаа, оршин суух зөвшөөрөл зэрэг бүх талын дэмжлэгийг гадаад харилцааны хэлтсийн нэг цэгийн үйлчилгээгээр үзүүлж байна.

## Ⅸ. Сургалтын төлбөр

※ Доорх хүснэгт нь ерөнхий баримжаа авах байдлаар хийгдсэн бөгөөд цаашдаа сургалтын төлбөрт өөрчлөлт орох боломжтой.

| Тэнхим | | Төлбөр |
|---|---|---|
| Олон улсын тэнхим | Global солонгос судлал | 4,198,000 вон |
| | Гоо сайхан, хувцас дизайн судлал | 5,893,000 вон |
| Солонгос хэл уран зохиолын тэнхим, англи хэл уран зохиолын тэнхим, герман хэл уран зохиол·соёлын тэнхим, франц хэл уран зохиол·соёлын тэнхим, япон хэл уран зохиол·соёлын тэнхим, хятад хэл уран зохиол·соёлын тэнхим, түүхийн тэнхим, Улс төр олон улсын харилцааны тэнхим, сэтгэл судлалын тэнхим, газар зүйн тэнхим, санхүү эдийн засгийн тэнхим, бизнесийн удирдлагын тэнхим, Бизнесийн удирдлага/глобал бизнесийн удирдлагын мэргэжилтэн), Хууль эрх зүйн тэнхим, Боловсрол судлалын анги, Нийгмийн ухааны боловсролын анги, Ёс зүйн боловсролын анги, Хятад ханз боловсролын анги, Сургуулийн өмнөх боловсролын анги | | 3,833,000 вон |
| Цэвэр шинэ материал инженерчлэлийн анги, Био хүнсний инженерчлэлийн анги Био амьдралын ухаан / Биотехнологийн инженерчлэлийн анги, Компьютерийн инженерчлэлийн анги, Үйлчилгээний дизайны инженерчлэлийн анги, Сувилахуйн ухааны анги, Хувцас загвар, хувцасны үйлдвэрлэлийн анги, Спорт шинжлэх ухааны салбар / сургууль | | 4,637,000 вон |
| Соёл урлагийн менежментийн анги, Медиа болон харилцаа холбооны анги, Нийгмийн халамж, Интеграцилсан аюулгүй байдлын инженерчлэлийн анги, Хэрэглэгч болон үйлдвэрлэлийн судалгааны анги | | 4,234,000 вон |
| Гоо сайхны үйлдвэрлэлийн анги, Дорнын уран зураглалын анги, Өрнөдийн уран зураглалын анги, Дүрслэх урлаг, сийлбэр баримлын анги, Гар урлал чимэглэлийн анги, Дизайны анги | | 5,374,000 вон |
| Медиа, кино дэлгэцийн жүжиглэх урлагийн анги, Орчин үеийн практик/орчин үеийн хөгжмийн анги, Бүжгийн урлагийн анги, Дуулаачийн анги, Хөгжмийн зэмсгийн анги, Хөгжмийн зохиомжийн анги | | 5,481,000 вон |
| Математик, статистик болон дата сайенс (өгөгдлийн шинжлэх ухаан)-ий салбар, Хими болон эрчим хүчний цогц/интеграцилсан инженерчлэлийн салбар, Био эрүүл мэндийн цогц/интеграцилсан салбар, Био шинэ эм болон анагаах ухааны салбар, Хиймэл оюун ухаан (AI) цогц/интеграцилсан салбар | | 4,940,000 вон |

## Ⅹ. Англи хэлтэй орны жагсаалт

| Тив | Улс | Тайлбар |
|---|---|---|
| Африк | Ботсвана, Камерун, Этиоп, Гамби, Гана, Кени, Лесото, Либери, Малави, Маврикий, Намиби, Нигери, Руанда, Сьерра-Леоне, Өмнөд Африк, Өмнөд Судан, Судан, Эсватини (хуучнаар Свазиланд), Танзани, Уганда, Замби, Зимбабве. | Үндэсний хэл нь англи хэлтэй орны жагсаалт нь Солонгос улсын гадаад харилцааны яамны цахим хуудсанд үндэсний хэл нь англи хэлээр бүртгэгдсэн улсууд болно. |
| Ази | Бруней, Хонконг, Энэтхэг, Малайз, Пакистан, Филиппин, Сингапур. | |
| Номхон далайн орнууд | Австрали, Фижи, Кирибати, Маршаллын арлууд, Микронезийн Холбооны Улс, Науру, Шинэ Зеланд, Палау, Папуа Шинэ Гвиней, Самоа, Соломоны арлууд, Тонга, Тувалу. | |
| Европ | Ирланд, Малта, Англи | |
| Америк | Антигуа ба Барбуда, Багамын арлууд, Белиз, Канад, Доминика, Гренада, Гайана, Ямайка, Сент-Китс ба Невис, Сент-Люсиа, Сент-Винсент ба Гренадин, Тринидад ба Тобаго, Америкийн Нэгдсэн Улс (АНУ). | |

# XI. Дотуур байр

## 1. Дотуур байрны мэдээлэл

※ Дотуур байрны төлбөр болон хугацаанд өөрчлөлт орж болно.

| Хувиарлалт | Төрөл | Төлбөр (1сэмистер) | Хугацаа | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Гадны гэрээт дотуур байр (6 байр) | 1 хүний | 2,940,000 вон | 2027 оны 1-р улирал<br>2027.02.24. ~ 06.30. | 6 барилгаас бүрдсэн гадаад оюутнуудад зориулсан дотуур байр |
| | 2~3 хүний | 1,750,000 вон | | |
| | 4 хүний | 1,537,500 вон | | |
| The House | 2 хүний | 2,097,380 вон | | |
| Сонмирюу | 1 хүний | 2,677,500 вон | | Нийтийн галтогоо, угаалгын өрөө, усанд орох өрөөтэй дотуур байр |
| | 2 хүний | 1,859,380 вон | | |
| | 3 хүний | 1,487,500 вон | | |
| | 4 хүний | 1,115,630 вон | | |

## 2. Дотуур байрны танилцуулга








**International Affairs and Services Team**

Address : (02844) 2, Bomun-ro 34da-gil,
Seongbuk-gu, Seoul, Republic of Korea

Tel : 02-920-7994

Email : intadmission@sungshin.ac.kr

Homepage : https://ipsi.sungshin.ac.kr

# SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY

성신여자대학교
SUNGSHIN WOMEN'S UNIVERSITY